

БАТЛАВ.  
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Д.ТӨМӨРБААТАР

2023 оны ... сарын ... өдөр



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН 21 ДҮГЭЭР ХОРООНД ГҮНИЙ ХУДГИЙН ЦООНОГ  
ГАРГАХ, НАСОС СУУРИУЛУУЛАХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Улаанбаатар хот

2023.12.01

№	Үзүүлэлтүүд
<b>1. Цооног өрөмдөх, тоноглох, шавхалт</b>	
<p>1.1. Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох, 1.2. Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилах ажилд тавих техникийн шаардлага MNS6088:2010 стандартыг мөрдөнө. 1.3. Цооногийн ашиглалтын ундарга: 3.6-6м<sup>3</sup>/цагт ус өгөх хүчин чадалтай байна. 1.4. Суултын яндангийн материал нь ган хоолой байх ба ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн олон улсын чанарын ISO гэрчилгээтэй байна 1.5. Цооногоос ус өргөх хоолойг диаметр 32 мм-ээс багагүй, материал нь ган хоолой, эсвэл хувинцар хоолой байна. 1.6. Ус шүүх хайрга нь шигшсэн мөлгөр хэлбэртэй тоосонцор хольцгүй мөхлөгийн хэмжээ 10-15мм-ээс багагүй байна. Тунгаагуурын гүн 2 метрээс багагүй 1.7. Худгийн шавхалт хийж цэвэрлэх 24 цагаас багагүй 1.8. Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх 1.9. Худгийг түр хугацааны тагаар тоноглох 1.10. Худгийн газрыг сонгохдоо: Гидрогеологийн хайгуулын судалгаанд үндэслэж иргэд малчдын сонирхол хүсэлтээр сонгохгүй байх</p>	
<b>2. Худгийн барилга, усан сан мал услах онгоц, талбай</b>	
<p>2.1. Худгийн барилга: - Хэмжээ: Дотор талдаа 3м*3м, ханын өндөр шалнаас дээш 2 метр өндөр - Материал нь тоосго, мод, хананы зузаан 38 см байна. - Хаалга нь 3 мм зузаантай листэн төмөр хаалга байна. - Худгийн нь дээд талдаа 30см*30см нээлхийтэй байна. Нээлхий нь цооног засвар үйлчилгээ хийхэд зориулагдана. - Худгийн цонх нь 40см*50см хэмжээтэй хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. /Цонхны байрлал нь мал услах онгоцны харалдаа байрлана. - Стандартад заасан худгийн барилга нь тоосгоор барина.</p> <p>2.2. Мал услах онгоцонд ус хүргэх хоолой нь 50 мм диаметртэй цонхны ханаас 2 м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доод талд гаргана. 2.3 Ундны ус авах хоолой нь 50 мм диаметртэй цонхны ханаас 2 метр урттай гадагшилсан ган хоолойг цонхны доод талд гаргана. /Ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгоно/. 2.4 Усан сан нь босоо суурьтай гагнаж хийсэн дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1.5 м<sup>3</sup> ээс багагүй багтаамжтай ган усан сан байна. Усан сан дээр модон тагтай. 2.5 Мал услах онгоц нь: Хэмжээ 9 метрээс багагүй урттай байна. Материал нь 400 мм-ийн голчтой хагас цилиндр ган яндан хоолой эсвэл цутгамал төмөр бетон байх Онгоцыг худгийн барилгаас 1-2 хэмийн налуутайгаар 2 метрийн зайнд байрлуулна. Онгоцны адагт үлдэгдэл усыг юүлэх жижиг нээлхий гарган. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эргэлдэж хаадаг байхаар хийнэ.</p>	

Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолыг усыг бүрэн шавхахаар байрлуулж гагнана.

Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна.

2.6 Мал услах талбайн хэмжээ: Мал услах онгоцны хоёр талд 1.0 метр урттай 0.5 метрын өргөнтэй цементэн хавтангаар мал услах талбайн хийж суурилуулна.

Материал М:250 маркаас доошгүй чанартай цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ бетоныг төмөр тороор хүчилтгэсэн байна.

Мал услах талбайн нь худгийн барилга болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуутай бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэгдэх зориулалттай байна.

### **3.Худгийн ус шавхуурга ус өргөх хоолой шүүр яндан**

3.1 Худгийн ус шахуурга: ISO9001:2015 стандартын шаардлага хангасан байх  
Ус шахуурганы хөдөлгүүр нь олон улсын EN60335-1,2012+A11 2014, AC2014 стандартын шаардлага хангасан 3 салаа цахилгааны утастай утас нь ус шахуургын удирдлагын самбараар дамжин цахилгаанд холбогдоно.

Ус шахуурга нь 2019 онд үйлдвэрлэсэн байх гарал үүслийн гэрчилгээг хавсаргах  
3.2 Цахилгааны утас: IEC60227-5 болон ISO 9001:2015 чанарын стандартын шаардлага хангасан. VCTF эсвэл түүнтэй дүйцэхүйц загварын 3 салаатай ус чийгээс хамгаалагдсан давхар бүрээстэй цооногт устай нөхцөлд ашиглах шаардлагыг хангасан байх утас нь ус шахуургаас хянах самбар хүртэл залгаасгүй үргэлжилсэн байх

Ус өргөх яндангийн 2 м тутамд бэхэлдэж/туузаар ороож болохгүй/ тогтооно.  
3.3.Ус өргөх хоолой: MNS ISO4427:2007 стандартад нийцсэн, анхдагч HDPE хувинцарын түүхий эдээр хийсэн байх, ажлын даралт доод тал нь 1.6 мПас-аас багагүй даралт даах чадвартай хар эсвэл цагаан өнгийн дотроо давхарга нь тунгалаг ундны ус дамжуулах зориулалттай байх.

3.4 Хянах самбар: Асаах унтраах товчлууртай ус шахуурга ажиллаж буйг /улаан/ гэрлээр асаах дохиололтой ус шахуурга ажиллуулах асаагууртай

3.5 Цахилгаан эх үүсвэр: 220ВТ цахилгаантай холбогдох бололцоотой бол холбох шаардлагатай, бололцоогүй бол бага оврын цахилгаан генератор суурилуулах

3.6 Худгийн шүүр яндан: 100 метр хүртэл гүнтэй цооног дахь шүүрийн яндангийн гадаад диаметр нь 150 мм-ээс дээш байна.

Хувинцар хоолой нь анхдагч түүхийн эд ашиглаж үйлдвэрлэсэн MNS5544 2007 чанарын шаардлага хангасан тохирлын гэрчилгээтэй байх ундны стандартын шаардлага хангасан лабораторын шинжилгээтэй байна.

3.7 Эргэлтэд цохилтод өрөмдлөгийн аргаар өрөмдсөн цооногт дахь шүүрийн янданд ус нэвтрүүлэх шүүрийг зориулалтын төхөөрөмжөөр хөндлөн байдлаар нэг эгнээнд 8-10 ширхэг, 40-80 мм хэмжээтэй цуулбарлан ашиглаж болно. Хоолой зузаан нь 3 мм-ээс багагүй байна.

### **4. Худгийн хүлээлгэн өгөх**

4.1.Талбайг цэвэрлэх / өрөмдлөгийн шлам барилгын болон ахуйн хог гэх мэт/

4.2.Худгийн паспорт ашиглалтын зааврыг бэлтгэж ашиглалтанд паспортыг бүрэн бөглөж Нийслэлийн Байгаль орчны газрын даргаар баталгаажуулан, комиссын актын хамт хүлээлгэн өгнө.

ХЯНАСАН:ТОХИЖИЛТ НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.НЯМХҮҮ

БОЛОВСРУУЛСАН: ТОХИЖИЛТ НИЙТИЙН АЖ АХУЙН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

С.СҮХЦООЖ